

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 11-р сарын 12-ны өдөр

№ 25/25

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн
гишүүнийг түр орлох этгээдийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйлийн 81.5 дахь заалт, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.17.1, 7.17.2 дахь заалт болон 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн санал хураалтын дүнгийн нэгтгэл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнийг түр орлох этгээдээр Бүрэндамба овогтой Бат-Уулыг томилсугай.
2. Б.Бат-Уул нь компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүний эрх, үүргийг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонгуульт хугацаа дуусах хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр томилогдсон Б.Бат-Уулд Монгол улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам, хурлын дэг болон бусад холбогдох компанийн засаглалын эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү), олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь) нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД